

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН “ПАНОПТИКУМ” ЗАГВАРЫН ТУХАЙ

Б. Галбадрах

*ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч,
доктор /Ph.D/, хошууч*

Товч агуулга: Олон улс орнууд гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэгтний аюулгүй болгох, нийгмээс тусгаарлах ажиллагаанд анхаарлаа хандуулж ирсэн байдаг. Гэмт хэрэгтнийг ял эдлүүлэх байгууламж буюу нийгмийн хэллэгээр хорих байгууллагын зохион байгуулалт, архитектурын олон санал, санааг дэвшүүлсэн байдаг. Түүнээс лэдгээр загваруудын нэг болох шоронгийн “паноптикум” загварын тухай тайлбарласан болно.

Түлхэлтс: хорих ял, хоригдол, паноптикум.

Хүний эрх, эрх чөлөөг хангах салбарт хамтран ажиллах нь олон улсын интеграцчиллын үйл явцад улс орны бодлогын чухал чиглэлийн нэг юм. Энэ төрлийн хамтын ажиллагааны зорилго нь интеграцчиллын хүрээнд хүний эрх% эрх чөлөөг хангах бие даасан хэм хэмжээний тогтолцоо, институцийг бүрдүүлэхэд оршдог. Олон эрдэмтэн, судлаачид хүний эрхийг хамгаалах бус нутгийн тогтолцоог бий болгох зорилго нь универсал буюу бүх нийтийн тогтолцоог тодорхой улс, бус нутгийн нийцүүл байдл дасан зохицоход агуулагддаг гэж үзсэн байдаг. Гэсэн хэдий ч нэг эдийн засгийн бүсэд соёл, төрхөн уламжлалд тулгуурлан үздэг бүрд хүний эрхийг хамгаалах бус нутгийн тогтолцоо нь бусад орны улс төр, нийгэм, соёл болон эдийн засгийн төвшинг нэгдмэл болгох зорилготой.

Хувь хүн дээрх төрийн эрх мэдэл нь тэдний үйл хийдл хяналт тавих хэлбэрээр хэрэгждэг. Нийгмийн ашиг сонирхлын анатоми нь эрх мэдлийн хүрээнд хяналт тогтоох хаалттай орчныг бүрдүүлэх, хувь хүний амьдралыг сүлдэрт аваачих зэрэгт хүргэдэг байна. Ийм хэлбэрээр онолын төвшинд захирагч ба төлөөлөгчийн талаарх асуудал үздэг. Энэ асуудлын агуулга нь ашиг сонирхол зорьсон, төлөөлөгчдийн зан байдлыг удирдах боломжгүй, хяналт тавихад бэрхшээлтэй үед зарим төлөөлөгчдийг захирагчдын шаардлагыг биелүүлэх, захирагдах албадлагын механизмыг дэлгэрүүлэх хэрэгцээг үүсгэдэг байна¹⁴¹. Энэ асуудал нь хууль, тогтоомж дүрэмд нийцдэггүй ашиг сонирхолтой хоригдлын ашиг сонирхлын талаар судалдаг эрхийн шийдвэр гүйцэтгэх шинжлэх ухаанд ч ач холбогдолтой. Хуулийн гадуур гишгэсэн гэмт хэрэгтнийг хорих ерөнхий шалтгаан нь тэдгээрийг нийгмээс тусгаарлан хатуу хяналт тогтоох төрийн хүсэл эрмэлзэл юм.

Пенитенциар шинжлэх ухааны эрдэмтэд хорих байгууллагын бүтээн байгуулалтын “түгс” хувилбарын талаарх долоон хүчин зүйлсийг боловсруулсан:

- 1) засан хүмүүжүүлэх үйл явц - хоригдлыг засан хүмүүжүүлэх нь ялын гол зорилго;
- 2) хоригдлуудыг үйлдсэн гэмт хэргийн байдал, нас, хувь хүний онцлог, засан хүмүүжүүлэхэд шаардагдах хандлага, дахин хүмүүжүүлэх боломжтой үе шат зэргээс хамааран ангилан хуваарилах;

¹⁴¹ Олейник А.И. Тюремная субкультура в России: от повседневной жизни до государственной власти. М., 2001.

- 3) ялын хэмжээ - ялтны хувийн шинж чанараас хамааран ялын хэмжээ харилцан өөрчлөгдөх;
- 4) хөдөлмөрийг эрх, өөргийн хувиар хоригдлыг нийгэмшүүлэхэд ашиглах;
- 5) хөмжүүлэх пенитенциар технологи, түүнийг ашиглах;
- 6) хорих ял эдлүүлэх байгууллагыг шаардлагатай техник, хэрэгсэл, хөний нөөцөөр хангах;
- 7) хоригдлыг засан хөмжүүлэхэд хяналт, албадлагын хэрэгслийг зохистойгоор хослуулах¹⁴².

Хоригдлыг засан хөмжүүлэх өр дөнтөйд тооцогдож байсан хоригдлыг байршуулах механизмыг судлан үзье.

XVIII зууны дунд өд пенитенциар¹⁴³ асуудлаар мэдээлэл солилцох талаар анхны үзэл санаанууд гарч эхэлсэн байдаг. Өөнд пенитенциар шинжлэх ухааныг үндэслэгч английн эрдэмтэн, судлаачид болох Дж. Говард, И.Бентам нарын дэлхий дахинд түүгээн дэлгэрүүлсэн үзэл санаанууд нөхцөл үзүүлсэн.

Английн гүн ухаанч, социологич И.Бентам XVIII зуунд “паноптикум” буюу “бүхнийг харагч” гэх байгууллагын удирдлагын тогтолцоог боловсруулсан. Тэрээр 1786-1787 онд Г.А. Потемкин хааны аж үйлдвэрлэлийн төсөл дээр ажилладаг байсан өөрийн ах Самуил дээр Оросын Хаант Улсын бүрэлдэхүүнд багтаж байсан КричевЧериковскийн мужид¹⁴⁴ зочлон очсон байдаг бөгөөд чухам тэнд И.Бентам паноптикумын талаарх Самуилын үзэл санаатай танилцсан юм¹⁴⁵. Энэ үзэл санаа нь тойрог цилиндр хэлбэртэй барилгын дунд энгийн ажилчдад хяналт тавих ахлах ажилчдын суух цамхгийг байгуулахад оршиж байсан¹⁴⁶. Өөний дараагаар Иеримия Бентам энэ загварын шоронд зохицуулан боловсруулсан бөгөөд хэд хэдэн захиаг Англи Улсруу илгээсэн байдаг. Хяналтын зарчмыг тэрээр шоронгийн захиргаа, удирдлагыг талаар санаагаар баяжуулсан ба өөнд шоронгийн захирал нь өөрийн өөргийг гүйцэтгэснийхээ төлөө ямар нэгэн ашиг олохоор тооцоолсон байна¹⁴⁷.

Паноптикум нь тухайн өөийн шоронгуудтай харьцуулахад илүү хямд байх бөгөөд учир нь төөнд ажиллах ажилтны тоо бага байхаар тооцоологдсон. И. Бентам “Энэ загвар дээр үндэслэн шорон барихыг зөвшөөрнө өө. Би өөрөө шоронгийн хянагч больё. Хянагч ямар нэгэн цалин хөлс авахгүй, улсаас ямар нэгэн зардал гарахгүй, та бүгд өөнийг харах болно” гэж Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хороонд хандан хэлсэн байдаг¹⁴⁸. Бентамын санал болгосны дагуу хоригдлууд хөдөлмөрлөх ёстой байсан бөгөөд ингэснээр шоронгийн урсгал зардлыг багасгах, орлого олох боломж бүрдэнэ гэж харж байсан.

Оросын Хаант Улсаас Англид эргэж ирмэгцээ Бентам паноптикум-шоронгийн үзэл санаагаа өргэлжлүүлсэн бөгөөд архитектор Вилли Ревелид ноорог зураг гаргуулахаар захиалсан байна. Тэрээр 1791 онд ном нийлүүлэн гаргаж өөрийн санааг хөгжүүлэн өргэлжлүүлсэн байдаг. Ирланд болон хувьсгалт Францын удирдагчдын сонирхлыг татах амжилтгүй оролдлогын дараагаар

¹⁴²Фуко М. Надзирать и наказывать. Рождениетюрьмы. М., 1999.

¹⁴³Цаашид бид пенитенциар гэх нэр томьёог ашиглах бөгөөд энэ нь хорих ял эдлүүлэх ажиллагааг ойлгож болох юм.

¹⁴⁴Одоогийн Беларусь Улсын газар нутаг.

¹⁴⁵Өөний дараагаар нэг бус удаа энэ үзэл санаа өөрөө хөдлэн зөвшөөрсөн байдаг

¹⁴⁶The Works of Jeremy Bentham, vol. 4 (Panopticon, Constitution, Colonies, Codification). С. 99-100. URL: http://oll.libertyfund.org/titles/bentham-the-works-of-jeremy-bentham-vol-4#lf0872-04_head_004


¹⁴⁷Мөн тэнд. 134-140 дэх тал.

¹⁴⁸Мөн тэнд. 29 дэх тал.

Английн ерөнхий сайд УильямПиттэд хаягдсан байсан боддэсний пенитенциар тогтолцооны зураглалыг сэргээж, паноптикумыг бүтээн байгуулах талаар итгэл нэмшлийг төрүүлэхийг хичээж байсан. Эцсийн эцэст тэрээр УильямПитт болон төслийн зөвлөхүүдэд итгүүлж чадсан ба 1794 онд төслийн урьдчилсан ажлыг эхлүүлэхээр төнд 2000 фунт стерлингийг олсон байдаг^{149 150 150}.

1799 оны 11 дүгээр сард Бентам Улсаас олсон мөнгө р титмийн нэрийн мөнөөс 12000 фунт стерлингээр газар худалдан авсан. Гэвч тус газар нь барилга барихад төдийлөн тохиромжгүй намгархаг мөн хэтэрхий жижиг байсан. Гэсэн хэдий ч тэрээр жижиг хэмжээний туршилтын шорон барих зорилготой гэх шалтгаанаар засгийн газраас илүү их газар, мөнгө олгохыг хэссэн ч дэмжлэг аваагүй байна. Бентам төслийг засгийн газар зэл баримтлалын өрнөлдөнд итгэхгүй байсан зэргээр тайлбарласан байдаг. Барилгын талаарх хэлцэл өргөлжилж байсан ч 1801 онд Питт огцорч, 1803 онд Аддингтоны шинэ засгийн газар төслийг өргөлжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн байна. Гэсэн хэдий ч хожим нь засгийн газраас боддэсний пенитенциар тогтолцооны зэл санааг, 1811-1812 онуудад паноптикумын төслийг сэргээсэн байдаг. Хожим нь шоронг УильямУильямсын загварыг барьсан байна.

XIX зуунд дэлхий дахинд паноптикум нь “presidio modelo” зарчмаар шоронгийн бүтцийг тодорхойлоход барихад нөлөөлсөн байна.И.Бентамын адилаар баян гэр бэлээс гаралтай Дж. Говард өйл ажил хэргээ өргөлжүүлж байсан ба тэрээр бүхий л амьдралаа хөний сайн сайхны төлөөр зориулсан байдаг. 1773 онд тэрээр Английн Берфорд хотын шүүгчээр томилогдож шоронгийн нөхцлийг сайжруулах хэрэгтэйг тэмдэглэсэн хэлсэн байна.



150

И. Бентам паноптикум нь “ёс суртахууныг сэргээх, эрүүл мэндийг хамгаалах, аж өйлдвэрийг бататгах, соён гэгээрлийг төгөөн дэлгэрүүлэх, татварыг багасгах, эдийн засгийг бэхжүүлэх, муу санаатны зэл бодлын санааг таслах - энэ нь энгийн л нэг архитектурын тусламжтайгаар” гэж тэмдэглэн хэлсэн байдаг.

“Паноптикум” гэх нэг нь грек хэлнээс “бүхий л зөйл нь харагдах газар” гэсэн утгатай.

¹⁴⁹ Мөн тэнд. 102-104, 107-108 дахь тал.

¹⁵⁰ <https://ru.wikipedia.org/wiki/>

Эхлээд энэ грек бичиг нь бичгийн нийтийн орчны загварыг нэрлэх түүхтэй байсан ч түүнээс шоронгийн загварын нэр болох учиртай байжээ.



М.Фуко энэ загварыг “бичгийн л цэгийг ажигладаг, хувь хүн бичгийг тодорхой тогтоосон газар байрлуулдаг, бичиг хүндлүүлэхийг хязгаарласан, бичгийн л арга хэмжээг бүртгэн авдаг, бичиг хэсэг нь түүв удирдлагын цэгтэй холбогдсон, түүв л рсэн удирдлагатай, хувь хүнийг байнгын цоожилсон, түүнийг судалж байдаг хаалттай, сегментчилсэн газар” гэж тайлбарласан байдаг. Паноптикумын түүслийн гол зорилго нь хоригдлыг хорих байгууллагын алба хаагчийн байнгын хяналтад байлгахад оршисон. Түүнийг даган хяналт нь тасралтгүй, тогтмол байх ёстой байсан.

Паноптикумын загварыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хэрэгжүүлсэн байдаг. БНХАУ-ын Засгийн газраас Барууны орнуудад боломжгүй зүйлсийг бид бичгийн улсад хийж чадна гэж үзсэн бөгөөд түүнийг хийх арга зам нь техник, технологи бус соёл байсан байна. Түүний зорилго нь БНХАУ-ын иргэдэд тэдний хууль зөрчсөн үйлдлийг хэн нэгэн болон нийгэм тэр чигтээ харж, мэдэхээс ичгүүртэй байхад оршиж байсан. Чухам хятадууд хамгийн ихээр ичдэг бөгөөд түүний учир нь тэдний соёлд “күнзийн дэг журам”-д заасан тогтоосон хэмжээг дагах нь амьдралын гол зохицуулах хэрэгсэл болдог. Техникийн хяналтын тогтолцооны зорилго нь ард иргэдийг тэдний үйлдэх зөрчил, зан байдлын хэм хэмжээг нийтэд зарлаж гутамшиг болохоос эмээхэд оршиж байсан: “Хүмүүс тэдэнд хяналт тавьж байгаа эсэхийг мэдэхгүй. Энэ ойлгомжгүй байдал нь илүү дуулгавартай болгодог байна”¹⁵¹. Энэ тогтолцоогоо тэд мөн “паноптикум” гэж нэрлэсэн бөгөөд хүмүүс тэднийг хянаж байгаа эсэхийг баттай мэддэггүй гэсэн агуулгатай.

Паноптикум түүслийг хэрэгжүүлсэн өөр нэгэн газар хэрэгжүүлсэн ПресидиоМодело гэх шоронгийн байгууламж болсон юм. Уг байгууламжийг 1926-1931 онд Куб Улсын Пинос арал дээр байгуулсан байдаг. Шоронг байгуулах тушаалыг тухайн үеийн удирдагч ХерардоМачадо түүсн байна. Байгууламж нь 5 түвшин бичгий тойрог хэлбэрийн 4 барилгаас бүрдсэн байна. Түүрүүр хэлбэл энэ нь паноптикумын загвар юм. Шоронгийн байгууламжид 6000 хоригдлыг байршуулахаар тооцолсон байдаг ч бодит байдал дээр энэ тоо нэлээдгүй

¹⁵¹ Мазур П. Внутрикитайскойаптиутопическоймечты, ИИстыд и множество идеокамер.

хэтэрсэн байдаг. Эдгээр барилгуудын дунд цонхоор хоригдлуудад хяналт тавих тэрэгтэй ээлжийн хянагч байх цамхаг байрладаг байсан. Хянагч болон хоригдлууд шууд уулзах боломжтой байсан бөгөөд хянагч нь цамхагаас тусгай хонгилоор гарч явдаг байсан. Байгууламжийн 4 барилга нь 5 дахь барилгын дэргэд талд байрлаж байсан ба дундуураа холбогддог байжээ. Тав дахь барилгад 3000 хоригдолд тооцоолсон хоолны газар байрлаж байсан байна.



152

Дээрхээс дүгнэн паноптикумын зарим давуу болон сул талыг хэлж болох юм. Төслийн давуу талд дараахыг хамааруулж болно. Үүнд:

- олон хоригдолд хяналт тавих боломжтой ба хянагчийн эсрэгээрээ бага байна;
- паноптикум нь техникийн, ажиллах хичинд зарцуулах зардлыг багасгадаг;
- паноптикумын загвараар баригдсан барилгуудад хоригдолд шоронгийн удирдлага, олон нийтийн төлөөлөл ч хяналт тавих боломжтой. Бусад хорих байгууллагуудын адил аливаа зөрчлийг гаргахгүйн тулд төрийн байгууллагаас тогтмол хяналт очдог байсан;
- хоригдлуудыг нэг нэгнээс нь тусгаарлан байрлуулах;
- төртөд дүгнэлт хийх боломжийг олгодог. Ганцаарчлан хорьсноор тухайн этгээд нь төрийн буруу үйлдлээ тунгаан бодож гэмшдэг байна.

Төслийн сул тал:

- хаалттай орон зайг мэдрэх;
- хяналтаас далд байх боломжгүй, хэсэгхэн хугацаанд ч бусад хоригдлуудын дунд байх боломжгүй;
- засан хэмээх жөлөх, сургалт, эмнэлгийн үйлчилгээ зөвлөхөд хяндралтэй. Хоригдлуудыг заавал нэг нэгээр нь зорьсон гаргаж авч явах шаардлага үүсдэг зэрэг.

Паноптикум нь хоригдолд тасралтгүй хяналт тавих ололттой загвар болсон бөгөөд хожим нь тус загвараар Филадельфийн улсын шорон 1829 онд, Лондон дахь Пентонвил, дараагаар Умард Ирландад Арма Гаол шоронгууд баригдсан төлөхтэй.